

Маргааны товч

Нийслэлийн Засаг даргын 2020.09.30-ны өдрийн А/1158 дугаар “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” захирамжаар Г.Баттүшигт ... 2655 м.кв бүхий газрыг төвлөрсөн авто машины зогсоол, үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон. Мөн Засаг даргын 2021.08.20-ны өдрийн А/646 дугаар захирамжаар уг маргаан бүхий газрын хэмжээг нэмэгдүүлж 2830 м.кв болгон газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, гэрээ байгуулжээ.

Улмаар Нийслэлийн Засаг дарга 2024.04.08-ны өдрийн А/397 дугаар захирамжаар дээрх газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгохдоо “... Нийслэлийн мэргэжлийн хяналтын 2021.08.17-ны өдрийн 02-04-126/777 дугаар улсын байцаагчийн дүгнэлт”-ийг үндэслэл болгосон байна.

Г.Баттүшигээс Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/397 дугаар захирамжийг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргаж, үндэслэлээ “... маргаан бүхий газартай холбоотой нийтийн эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн талаар эрх бүхий байгууллагын дүгнэлт гараагүй байхад энэ талаар дүгнэлт гарсан гэж үзэж, нэхэмжлэгчийн газар эзэмших эрхийг дуусгавар болгож шийдвэрлэсэн нь үндэслэлгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлтүүд нь нэхэмжлэгчид хамааралгүй, сонсох ажиллагаанд огт яригдаагүй, Хүрээ амаржих газартай давхцалгүй ...” гэж,

хариуцагчаас “... Нийслэлийн мэргэжлийн хяналтын 2021.08.17-ны өдрийн 02-04-126/777 дугаар улсын байцаагчийн дүгнэлтэд газар эзэмших эрхийн гэрээний нөхцөл болзлыг зөрчсөн нь тогтоогдож байгаа тул газар эзэмших эрхийг хүчингүй болгосон нь үндэслэлтэй” гэж тус тус маргажээ.